

Оюуны өмчийн газрын авлигын эсрэг үйл ажиллагааны

2014 оны төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
1	Байгууллагын нийт ажилтнуудад зориулсан авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах	<p>Байгууллагын мэдээллийн цагийн хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар танилцуулга хийж, АТГ-аас тараасан гарын авлагыг нийт ажилтнуудад тараах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Байгууллагын мэдээллийн самбар болон авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах зориулалт бүхий самбарт АТГ-аас ирүүлсэн болон мэдээлсэн мэдээллийг байршуулсан.</p>
2	Олон нийтийн арга хэмжээний үеэр байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагаа явуулах тухай мэдэгдэх	<p>Монгол Улсын Шадар сайдын харьяа байгууллагууд, тэр дотор Оюуны өмчийн газар өөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 2014 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 12:00-17:00 цагийн хооронд Чингисийн талбайд "Нээлттэй өдөрлөг" зохион байгуулж "төрийн байгууллагад байгаа авилгал, хүнд суртал, хариуцлагагүй байдлыг таслан зогсоох, хариуцлага хүлээдэг ёс суртахуунтай албан хаагч байх" уриалгад нэгдэн оролцсон</p>
3	Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмын шинэлэг зүйлийн талаар танилцуулах, ажилтнуудын ХАСХОМ хугацаанд нь бүрдүүлэн бүртгүүлэх боломж, мэдээллээр хангах	<p>Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн доорх гарын авлагыг тус байгууллагын ажилчдад тарааж өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Нийтийн албан тушаалтан танд ➤ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль <p>Мөн ХАСХОМ хугацаанд бүрдүүлэн бүртгүүлэх боломж, мэдээллээр хангаж ажилласан</p>
4	Тус байгууллагаас санал оруулахаар бэлтгэгдэж байгаа хууль, төслийн журмуудыг нийтэд танилцуулж, санал өгөх боломжоор хангах	<p>Тус газраас "Патентийн тухай хууль", "Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн төсөл боловсруулахаар ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгүүд тус хуулиудад оруулах өөрчлөлтийн талаар саналаа өгөх урилгыг холбогдох ТББ, төрийн</p>

		байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд энэ талаар санал авах тухай мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулсан.
5	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн бодлогын ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах	Байгууллагын сул орон тооны талаарх мэдээллийг тухай бүр ТАЗ-өөр дамжуулан нийтэд зарладаг бөгөөд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудитын хяналт шалгалт тогтмол хийлгэдэг. Байгууллагын цахим хуудсанд Мэдээллийн ил тод байдлын буланг нээж холбогдох мэдээллүүдийг байршуулсан.
6	Авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, тус төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр нь хэрэгжүүлдэг болно.
7	Газрын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авах арга хэрэгслийг боловсронгуй болгох, түүнийг хүлээн авч шийдвэрлэх ажилд дүн шинжилгээ хийх	Тус байгууллагын үйл ажиллагааны талаарх санал, шүүмжлэл, гомдлыг Засгийн газрын 11-11 төвөөр, өөрийн байранд болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан хүлээн авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд гомдол гарсан тохиолдол бүрт холбогдох арга хэмжээнүүдийг авч ажилласан.